



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/199

Зуунмод

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн
гурван талт хороо шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Хорооны дарга:

Г.Сурмаа (Аймгийн Засаг даргын орлогч)

Дэд дарга:

Д.Оюун (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга)

Гишүүд:

Д.Мөнхцэцэг (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Д.Оюундэлгэр (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөрийн хэлтсийн дарга)

М.Мэндсүрэн (Ажил олгогч эздийн холбооны удирдах зөвлөлийн
гишүүн)

З.Ариунболд (Ажил олгогч эздийн холбооны удирдах зөвлөлийн
гишүүн)

Б.Баярмагнай (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны
хуульч, өмгөөлөгч)

Ж.Энхээ (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны зохион
байгуулагч)

Нарийн бичгийн дарга:

Р.Алтанцэцэг (Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн)

2. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны үйл ажиллагааны үр дүнг Салбар хорооны хурлаар улирал бүр хэлэлцүүлж, үйл ажиллагааны зардалд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг салбар хорооны нарийн бичгийн дарга (Р.Алтанцэцэг)-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/527 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010502

My doc: zahiranj 2023-1 uliral. s/maa



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/204

Зуунмод

Байгууллагын дүрэм, бүтэц орон
тоог өөрчлөн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8, 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоол, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүрмийг нэгдүгээр, бүтэц орон тооны өөрчлөлтийг хоёрдугаар, ажилтан албан хаагчдын ажил үүргийн чиглэлийг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Ж.Даш-Яйчил)-д ДААЛГАХ нь:

2.1. Дүрмийг мөрдөж байгууллагын зорилт чиг үүргийг бүрэн хангаж ажиллах.

2.2. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан Улсын ахлах байцаагч, Улсын байцаагчдын орон тоог шийдвэрлэж, албан тушаалын тодорхойлолтыг батлуулах.

3. Захирамжийн хэрэгжилт, агентлагийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/647 дугаар захирамжийн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010492
My.Doc.zahiranj 2023 1ulral

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 27 ны өдрийн 17204 дүгээр
захирамжийн 1 дүгээр хавсралт

ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1. Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Байгаль орчныг хамааалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон салбарын нийтээр дагаж мөрдөх хууль, Засгийн газрын тогтоол, дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгож ажиллана.

2. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь /цаашид "газар" гэнэ/МонголУлсынЗасгийнгазрын 2021 оны 12 дутаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан аймгийн засаг даргын Тамгын газрынбүтэц,оронтоо, удирдлагын бүдүүвчийн дагуу байгуулагдсан аймгийн нутаг дэвсгэрт байгальорчныгхамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлогошийдвэрийгхэрэгжүүлэхүүрэгбүхий нутгийн захиргааны байгууллага мөн.

3. Газрын үндсэн зорилго нь: Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлал, хяналт шалгалтын хууль тогтоомжийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх,байгаль орчин аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, ус цаг уур орчны шинжилгээний газрын үйл ажиллагааг салбарын бодлого хөтөлбөртэй уялдуулан чиглүүлэх, байгаль орчин, аялал жуулчлалын сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэх,иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах, таатай орчин бүрдүүлэх, байгалийн нөөц баялгийг даацын нь хүрээнд ашиглах, хамгаалах нөхөн сэргээх, тогтвортой хөгжлийг хангуулахад хуулийн сахин мөрдөлтөд төрийн өмнөөс хяналт тавьж ажиллахад оршино.

4. Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын байгаль орчин, аялал жуулчлалын бодлого, тогтоол, шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгон тэднээс мэргэжил аргагүйн удирдамж авч Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад, сав газрын захиргаа, аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэстэй ажлын уялдааг хангаж ажиллана.

5. Газар нь аймгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх, хяналт тавих, аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар тогтмол хангаж, хэрэглэгчдийг байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалтай холбогдолтой мэдээллээр хангах, экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

6. Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэнтамга, тэмдэг,албан бичгийн хэвлэмэл хуудасхэрэглэх ба үйл ажиллагааны чиглэлийг илэрхийлсэн дүрслэл бүхий таних тэмдэгтэй байж болно.

7. Төрийн сангийн харилцах данстай байна.

8. Газар нь хөдөлмөрийн дотоод журамтай байна. Хөдөлмөрийн дотоод журмыг албан хаагчдын хурлаар хэлэлцүүлж газрын даргын тушаалаар баталж мөрдүүлнэ.

Хоёр: Газрын удирдлага, бүтэц

1. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймгийн Засаг дарга томилно.

2. Газар нь харъяандаа сум дундын ойн ангитай байна, мөн сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн буюу улсын байцаагч нарыг бодлогоор хангаж, үүрэг чиглэл өгч ажиллана.

3. Газар нь үүрэг, зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар газрын даргад зөвлөх эрх бүхий зөвлөлийг ажиллуулах бөгөөд зөвлөл нь 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд газрын даргын тушаалаар батлана. Зөвлөлийг газрын дарга удирдаж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг өөрийн тушаалаар батална.

4. Зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй ажиллана.

а/ Газрын жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх.

б/ Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, баримт бичгийн шийдвэрлэлт түүнд тавих дотоод хяналтыг зохион байгуулах журам, ажлын цаг ашиглалтын журам, газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмын хэрэгжилтэнд хяналт тавих, мөрдүүлж ажиллах.

в/ Ажилтан, албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, зохицуулах, санал солилцох, мэдээллээр хангах, санал дүгнэлт, зөвлөмж гаргах.

г/ Байгууллагад шинээр ажилтан авах, ажил албан тушаал өөрчлөн томилох, чөлөөлөх, халах, ажилтан албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тодорхойлох.

д/ Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх.

е/ Хууль тогтоомж зөрчсөн, газрын хэмжээнд мөрдөж буй журмуудыг зөрчсөн, хүнд суртал бий болгосон, ажилдаа хариуцлагагүй хандсан, ажлын байрны тодорхойлолтонд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагчдыг зөвлөлийн хурлаар оруулан зөрчилд тохирсон арга хэмжээ авах санал оруулах.

5. Газрын дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана.

а/ Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

б/ Газрын дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, ажлын байрны тодорхойлолтыг батлах, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчмаар ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулж ажиллах;

в/ Газрын албан хаагчдыг зохих хууль журмын дагуу томилох, чөлөөлөх, ажилтнуудыг шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

г/ Батлагдсан төсвийг захиран зарцуулах;

д/ Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах;

е/ Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

ё/ Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр аймгийн Иргэдийн

ж/ Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг бүрэн хангах;

з/ Сум, сум дундын ойн ангийг харьяалах;

Гурав. Газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын чиглэлээр төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах:

3.1.1. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурал, Засгийн газар, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын батлагдсан байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-т байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах;

3.1.2. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан зарлигийг орон нутагт хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг ханган ажиллах;

3.1.3. “Төсвийн тухай хууль”-ийн 58-р дугаар зүйлийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих;

3.1.4. Байгаль орчны салбарын дүрэм журам стандартуудыг мөрдүүлэх, сурталчилах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.5. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгагдсан тодорхой арга хэмжээг хариуцан зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

3.1.6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах-байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх замаар санхүүгийн баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр аймаг, сум, орон нутагт хэрэгжүүлэхтөсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр эхлэх төслүүдийг үнэлгээнд бүрэн хамруулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулийн дагуу эрх үүргийнхээ хүрээнд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийн талаархи тайланг жил бүр Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд хүргүүлж байх;

3.1.8. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэ ажилд байгууллага, иргэдийн хүч оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.9. Нутгийн ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Байгаль орчныг хамгаалах болон аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах, мэргэжлийн ажилчдыг сургах, давтан сургах боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх;

3.1.10. Аймгийн байгаль орчны төлөв байдлын тайланг 2 жил тутам гаргах.

3.2. Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглуулах чиглэлээр:

3.2.1. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг авах, Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх, түүнд холбогдох талуудын оролцоог хянах ажлыг зохион байгуулах;

3.2.2. Байгаль хамгаалагчдыг сонгон шалгаруулах, мэргэжлийн удирдлагаар тогтмол хангаж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, шагнаж урамшуулах, байгаль хамгаалагчдыг бие хамгаалах техник хэрэгсэл, унаагаар хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.2.3. Байгаль орчинд холбогдолтой судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах;

3.2.4. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох. тэдгээрийг мөрдүүлж ажиллах;

3.2.5. Ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх. улсын захиалга, даалгаварт ажлын хэрэгжилтийг орон

нутагт зохион байгуулах, агаар, ус, хөрсийг бохирдлоос хамгаалах, хяналт шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд ус цаг уур орчны шинжилгээний газрыг татан оролцуулах, Хог хаягдал, химийн бодисын менежментийг хэрэгжүүлэх;

3.2.6. Ой хээрийн түймрээс сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагад хандах;

3.2.7. Байгаль орчныг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, үүний дотор ойжуулах, ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх, хаягдалгүй технологи нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тухайн аймагт энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд болон ой, ус, ургамал, ангийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах;

3.2.8. Аймаг, орон нутгийн хэмжээнд ой, ус, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялгийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх;

3.2.9. Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгалийн нөөц, дурсгалт газрын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтыг хариуцах;

3.2.10. Аймгийн ойн сангийн тооллого явуулах, өөрчлөлтийг тооцон мэдээлэх, ойн ашиглалт, хамгаалалтын бүс, хот суурин газрын ногоон бүсийг тогтооход санал өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

3.2.11. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд ойн санг эзэмшүүлэх, ашиглуулах талаар баримт материал бүрдүүлэх, гэрээ байгуулах, батламжлуулахад мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх;

3.2.12. Ойн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэнд технологийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах;

3.2.13. Аймаг, бүс нутгийн байгаль орчинд зохицсон, зохих материаллаг бааз бүхий мод ургамлын үржүүлгийн газар байгуулж, тарьц, суулгац ургуулах, мод сөөгийн үрийн нөөц сан бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах замаар сайн чанарын үр, тарьц суулгац бэлтгэж орон нутгийн хэрэгцээг хангах;

3.2.14. Мод бэлтгэх талбайг тусгаарлах, мод бэлтгэлийн ажилд технологийн хяналт тавьж, мод бэлтгэсэн талбайг хүлээн авч дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах;

3.2.15. Мод, модон түүхий эд бэлтгэдэг мэргэжлийн байгууллагуудыг сонгон шалгаруулж, техник, технологийн өндөр түвшинд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж, зах зээлд чанар сайтай модон материал нийлүүлэх ажиллагааг дэмжих замаар хууль бусаар мод бэлтгэхийг хязгаарлах ажлыг орон нутагт модны хэрэгцээг хангахтай уялдуулан зохион байгуулах;

3.2.16. Орон нутагтаа байгаа ховор, нэн ховор ургамлын тархац, нөөцийн судалгааг үндэслэн, ховордсон ургамлын мэдээллийн сан байгуулж нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулах;

3.2.17. Ховор, нэн ховор ургамлыг тарималжуулах ажлыг зохион байгуулах;

3.2.18. Аймгийн усны нөөц, түүний зохистой ашиглалт, хэрэглээний байдлыг тогтмол үнэлж усны мэдээллийн сангийн сүлжээ байгуулах;

3.2.19. Гадаргын усны тооллого хийж, ширгэж хатсан гол горхи, рашаан, булаг, шандны тоо, мэдээллийг гаргаж холбогдох дээд байгууллагыг мэдээллээр хангах;

3.2.20. Усны нөөц, эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, зарим гол нуурын усыг салаалах, шар усыг тогтоон барих, борооны усыг хуримтлуулах усан сан байгуулах зэрэг арга хэмжээг нутаг орны байдалд тохируулан зохион байгуулах;

3.2.21. Бүх төрлийн худгуудын ашиглалтад хяналт тавих, эзэн хариуцагчтай болгох ажлыг зохицуулан зохион байгуулах;

3.2.22. Усны чиглэлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах арга хэмжээг зохион байгуулан мэргэжлийн ажлын багуудыг бий болгох;

3.2.23. Агаарын бохирдол, хог хаягдал, био аюулгүй байдлын асуудлуудаар бодлогын хэрэгжилтийг хангах;

3.2.24. Улсын тусгай хамгаалалттай газрын болон усны Сав газрын захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хянаж хэрэгжилтийг хангуулах;

3.2.25. Газар, түүний хэвлийг хамгаалах, нөхөн сэргээх талаар Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, тогтоомжид заасан арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

3.2.26. Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг тухайн хамгаалалтын захиргаатай хамтран боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гаргуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах, хамгаалалтын захиргаатай үйл ажиллагаагаа уялдуулах;

3.2.27. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төслүүдийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамруулах болон байгаль орчны хуваарьт аудитыг хийлгэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.2.28. Харьалах төслүүдэд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, шинжээчээр дүгнэлтийг баталгаажуулах болон уг төслүүдийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ, /-г хянаж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайланг хүлээн авч мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах;

3.2.29. Аймагт үйл ажиллагаа явуулж буй Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн төслүүдийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.30. Эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх;

3.2.31. Аймагт үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, зочид буудал, рашаан сувилал, тур операторуудын мэдээллийг жил бүр шинэчлэн гаргаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж байх;

3.2.32. Аялал жуулчлалын маршрут, шинээр бий болсон аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, эвент үйл ажиллагааны талаар байгууллага, иргэдийг мэдээллээр хангах, аялал жуулчлалын чиглэлийн сургалт, судалгааны ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах;

3.2.33. Орон нутагт аялал жуулчлалын дэд бүтцийг бүрдүүлэх, шинэ бүтээгдэхүүн бий болгох, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын менежментийг хэрэгжүүлэх;

3.2.34. Удирдах дээд байгууллагын шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, зөвлөгөө дэмжлэгээр хангах;

3.2.35. Аялал жуулчлалын статистик мэдээ, мэдээллийг аймгийн, холбогдох цахим хуудсанд байршуулах;

3.3. Байгаль орчны холбогдолтой багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр:

3.3.1. Байгаль орчны салбарын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан, хууль бусаар байгалийн нөөц, баялаг ашиглах, хүрээлэн буй орчныг бохирдуулах, доройтуулахаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажил зохион байгуулах;

3.3.2. Зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлж холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч хохирол, нөхөн төлбөрийг барагдуулах, гэмт хэргийн шинжтэй зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;

3.3.3. Газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, ой, ургамал, амьтан, агаарыг хамгаалах, тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, ой, хээрийг түймрээс хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, стандарт, хэм хэмжээ, дүрэм, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

3.3.4. Хайгуул судалгаа, шинжилгээний ажлын болон байгалийн, аялал жуулчлалын явцад байгаль орчны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих;

3.3.5. Монгол Улсын Улаан номонд орсон нэн ховор, ховор амьтан, ургамлын хамгаалалт, нөхөн сэргээлтэд хяналт тавих;

3.3.6. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтолыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт, байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн барагдуулалтад хяналт тавих;

3.3.7. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагийн төсөл, хөтөлбөрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдсан байдал, үнэлгээний дүгнэлт, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавих;

3.3.8. Химийн хортой болон аюултай бодисын худалдаалалт, хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, аюултай хог хаягдлын тээвэрлэлт, устгалтын байдалд хяналт тавих;

3.3.9. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалтын байдалд хяналт тавих;

3.3.10. Хот тосгон, бусад суурин газрын орчинд болон гол, мөрөн, нуур, рашаан, булаг, шандын эх, ундаргын орчныг хамгаалж эрүүл ахуйн бүс тогтоосон байдалд хяналт тавих;

3.3.11. Агаар, ус, хөрсөн дэх хими, биологийн хортой бодисын хүлцэх хэм хэмжээ, байгаль орчинд хаяж болох хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хяналт тавих;

3.3.12. Газрын хэвлийг ашиглах явцад болон ашигласны дараа гарч болзошгүй аюул, бусад хортой нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.13. Аялал жуулчлалын талаар мөрдөж байгаа хууль тогтоомж, тэдгээрийг үндэслэн Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.14. Аялал жуулчлалын байгууллага болон жуулчны үйлчилгээний байгууллага, хөтөч-тайлбарлагчийн үүргийн биелэлтийг хангуулах, тур оператор, тур агент, жуулчны бааз болон хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэл тогтоох журам, тухайн ангилал зэрэглэлд тавигдах үндсэн шаардлага, холбогдох стандартын мөрдөлтөд хяналт тавих;

3.3.15. Хууль тогтоомжид тусгайлан заагдсан бусад эрх үүрэг.

3.4. Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх чиглэлээр:

3.4.1. Байгаль орчныг хамгаалах тухай³ хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 37 дугаар зүйлийн

3.4.2. Байгаль орчны мэдээллийн улсын сангийн мэдээ, баримтыг бүрдүүлэн Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хуулийн хугацаанд хүргүүлж байх, статистик мэдээлэл нэгтгэж гаргах;

3.4.3. Байгалийн нөөц баялгийн талаарх мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн, холбогдох байгууллага, иргэдэд байгаль орчны мэдээллээр үйлчлэх;

3.4.4. Судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах;

3.4.5. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох, зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглуулах;

3.4.6. Аймаг, нийслэлийн усны нөөц, түүний зохистой ашиглалт, хэрэглээний байдлыг тогтмол үнэлж усны мэдээллийн сан байгуулах, гадаргын усны тооллого хийх, ширгэж хатсан гол горхи, рашаан, булаг, шандын тоо, мэдээллийг гаргах, холбогдох дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;

3.4.7. Газар зүйн мэдээлэлд суурилсан мэдээллийн сан хариуцах.

Дөрөв. Хүний нөөц, Ил тод байдлыг хангах

4.1. Ажилтнуудын хувийн хэргийн мэдээ баримтыг байнга шинэчлэн бүрдүүлж, хүний нөөцтэй холбоотой мэдээ, судалгаа, тайланг хуулинд заасан хугацаанд мэдээллийн зохих санд хүлээлгэн өгөх;

4.2. Төрийн албан хаагчдыг Авлигатай тэмцэх тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг цагтухайд нь гаргуулах;

4.3. Газрын ажилтан, байгаль хамгаалагчдын мэргэжлийн болон ажил хэргийн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах;

4.4. Байгаль хамгаалагчдыг байгаль орчны чиглэлийн их дээд сургуульд эчнээгээр суралцуулах, давтан сургах, судалгаа авч нэгтгэн танилцуулах;

4.5. Удирдах дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт гаргах, иргэдийн өргөдөл гомдлыг барагдуулах;

4.6. Албан хэрэгт оны туршид үүсч хөтлөгдсөн баримт бичгүүдийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж, хэрэг бүрдүүлэх;

4.7. Баримтын хадгалалтын материаллаг суурь бий болгох асуудлыг үе шаттай төлөвлөн хэрэгжүүлэх /архивын өрөө тасалгаа, баримт хадгалах хэрэгсэл, хадгалалтын аюулгүй байдлын болон хамгаалалтын техник хэрэгсэл, хувиан олшруулах, түүнчлэн гэмтэлтэй баримтыг сэлбэн засах, сэргээн шинэтгэх техник хэрэгсэл, багс, бийр, цаас, цавуу, шугам, утас, зүү хайч/ гэх мэт;

4.8. Байгууллагын ил тод байдлыг Засгийн газрын 143 тоот тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Тав. Газрын санхүүжилт, өмч хөрөнгө,

5.1. Газрын санхүүжилт нь дор дурдсан эхүсвэрээс бүрдэнэ.

5.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцад батлагдсан улсын төсвийнхөрөнгө;

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх арга хэмжээгхэрэгжүүлэхэдзориулан орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө;

5.1.2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний дагуу тухайн жилд газраас нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд зориулан улсын төсвөөс олгосон хөрөнгө;

5.1.3. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай" Монгол улсын хуулиар зохицуулагдах хөрөнгийн тодорхой хэсэг;

5.1.4. Газар нь өөрийн өмч хөрөнгөтэй байж, түүнийгээ холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

5.1.5.Төсөв санхүүгийн ил тод байдлын хүрээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Зургаа. Бусад

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүрмэнд аймгийн Засаг даргын Захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.

6.2. Дүрмэнд тусгагдаагүй асуудлыг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

6.3. Энэхүү дүрмийг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

___оОо___

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 27-ны өдрийн 4204 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал	
		ТЗ	ТҮ
1	Удирдах ажилтан /Газрын дарга/	1	-
2	Гүйцэтгэх ажилтан /Ойногжийн дарга /	1	-
3	Гүйцэтгэх ажилтан /Ойногжийн мэргэжилтэн/	1	-
4	Гүйцэтгэх ажилтан /Бодлогын мэргэжилтэн/	8	-
5	Гүйцэтгэх ажилтан /Байгаль хамгаалагчид/	35	-
6	Гүйцэтгэх ажилтан /Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч/	1	-
7	Гүйцэтгэх ажилтан /Байгаль орчны хяналтын улсын байцаагч/	2	-
8	Гүйцэтгэх ажилтан /үйлчилгээний ажилтан /	-	9
Нийт		58	

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1.Удирдах ажилтан			
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	Ахлах түшмэл ТЗ-4	1
2.Бодлогын мэргэжилтэн			
2	Газар, газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, тусгай хамгаалалттай газар нутаг, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээхариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-8	1
3	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилт, хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-9	1
4	Усны асуудал, төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-9	1
5	Агаарын чанарын асуудал, орчны бохирдол хог хаягдал, химийн хорт бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-9	1
6	Биологийн төрөл зүйл,мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-9	1
7	Аялал жуулчлал, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-9	1
8	Дотоод хяналт шалгалт, байгалийн гамшиг, хөрс хамгаалал, цөлжилт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсанмэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-9	1
9	Ойн ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл ТЗ-9	1
10	Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч	Дэс түшмэл ТЗ-6	1
11	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Дэс түшмэл ТЗ-7	2

3.Ойн нэгж			
12	Ойн нэгжийн дарга	Дэс түшмэл ТЗ-6	1
13	Ойжуулалт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (нэгжийн мэргэжилтэн)	Дэс түшмэл ТЗ-9	1
4.Үйлчилгээний ажилтан			
14	Нягтлан бодогч	ТҮ-8	1
15	Архив бичиг хэрэг	ТҮ-5	1
16	Нярав	ТҮ-4	1
17	Жолооч	ТҮ-3	1
18	Ногоон байгууламжийн сахиул	ТҮ-1	1
19	Жижүүр	ТҮ-1	3
20	Үйлчлэгч	ТҮ-1	1
5. Сумдын байгаль хамгаалагч нар			
21	Алтанбулаг сумын Байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	1
22	Батсүмбэр сумын Байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	8
23	Баяндэлгэр сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	2
24	Баянцогт сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	3
25	Баянчандмань сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	2
26	Борнуур сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	3
27	Жаргалант сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	3
28	Заамар сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	1
29	Мөнгөнморьт сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	4
30	Угтаалцайдам сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	1
31	Цээл сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	1
32	Эрдэнэ сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	4
33	Эрдэнэсант сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	1
34	Сүмбэр сумын байгаль хамгаалагч	Дэс түшмэл ТЗ-9	1

___оОо___

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 27-ны өдрийн 1204 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт



ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛ ҮҮРГИЙН
ЧИГЛЭЛ

№	Ажлын байр	Ажил үүргийн чиглэл
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	Нэг. Удирдан зохион байгуулах. 1/ Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; 2/ Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах; 3/ Газрын мэргэжилтнүүдтэй үр дүнгийн гэрээ, нийт албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ тус тус байгуулж, үр дүнг дүгнэх; 4/ Газрын албан хаагчдыг зохих журмын дагуу томилох, чөлөөлөх, ажилтнуудыг шагнах, урамшуулах асуудлыг шийдвэрлүүлэх; 5/ Газрын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гарсан хууль тогтоомж Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргаа төв байгууллага болон холбогдох агентлаг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах; 6/ Газартаа ойн нэгж байгуулах, сумын болон сум дундын ойн ангийн ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; Хоёр. Төсөв санхүүгийн асуудал. 7/ Батлагдсан төсвийг захиран зарцуулах; 8/ Байгаль орчны санд хөрөнгө төвлөрүүлэх, улмаар баталгаатай эх үүсвэрийг буй болгож, эдгээр хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, хэрэгжилтийг зохион байгуулах; 9/ Байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг сурталчлах, тогтвортой хөгжлийн боловсрол олгох чиглэлээр нөхөрлөл, хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагатай гэрээ байгуулж ажиллах, санхүүжилтийн асуудлыг төсөл, хөтөлбөр, байгалийн нөөцашигласны орлого, орон нутгийн хөгжлийн сан зэрэг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх; Гурав. Газрыг төлөөлөн бусад байгууллагатай харилцах. 10/ Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах; 11/ Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Төрийн захиргааны төв байгууллагыг бүрэн хангах;

		12/ Идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.
2	Газар, газрын хэвлий түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, тусгай хамгаалалттай газар нутаг, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээхариуцсан Ахлах мэргэжилтэн	Нэг. Газар, түүний хөрсийг хамгаалах 1/ Газар зохион байгуулалтын аймгийн ерөнхий төлөвлөгөө, сумдын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулахад хамтран ажиллах; 2/ Газар зохион байгуулалтын талаар явуулж байгаа нэгдсэн бодлого, газрын талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах; 3/ Аймаг,сумын газрын нэгдмэл сангийн тайланд дүн шинжилгээ хийн дүгнэлт гаргах; 4/ Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай” Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолын дагуу ойн болон усны сан бүхий газар, агнуурын байршил нутаг, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газарт хийгдэх орон зайн мэдээллийн нэгдсэн нэг санг бүрдүүлэн сумдын газрын албадтай хамтран ажиллах; 5/ Газар нутгийг орон нутгийг тусгай хамгаалалтад авсан тухай шийдвэрээ, холбогдох мэдээллийн хамт БОАЖЯ болон Ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт хүргүүлж байх; 6/ Газрын төлөв байдал, чанарын болон газар, газрын хэвлийн холбоотой эрхийн бүртгэлийн мониторингийг орон нутагт хэрэгжүүлж мэдээллээр БОАЖЯ-ыг хангах; 7/ Улсын тусгай хамгаалалттай газрын болон усны Сав газрын захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хянаж хэрэгжилтийг хангуулах; 8/ Газар, түүний хэвлийг хамгаалах, нөхөн сэргээх талаар Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, тогтоомжид заасан арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх; 9/ Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг тухайн хамгаалалтын захиргаатай хамтран боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гаргуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах, хамгаалалтын захиргаатай үйл ажиллагаагаа уялдуулах; Хоёр. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудал 10/ Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төслүүдийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамруулах болон байгаль орчны хуваарьт аудитыг хийлгэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах; 11/ Харьалах төслүүдэд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, шинжээчээр дүгнэлтийг баталгаажуулах болон уг төслүүдийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г хянаж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайланг хүлээн авч мэдээллийн санд оруулах ажлыг

		зохион байгуулах; 12/ Аймагт үйл ажиллагаа явуулж буй Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн төслүүдийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих; 13/ Эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх.
3	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилт, хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Нэг. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилт 1/ “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал”, “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”, “Байгаль орчин, ногоон хөгжлийн үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр зэрэг суурь баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудыг орон нутагт хэрэгжүүлэх; 2/ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр”-т байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах. Хоёр. Хүний нөөц, дотоод ажлын талаар 3/ Ажилтнуудын хувийн хэргийн мэдээ баримтыг байнга шинэчлэн бүрдүүлж, хүний нөөцтэй холбоотой мэдээ, судалгаа, тайланг хуулинд заасан хугацаанд мэдээллийн зохих санд хүлээлгэн өгөх; 4/ Төрийн албан хаагчдыг Авлигатай тэмцэх тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг цагтухайд нь гаргуулах; 5/ Газрын ажилтан, байгаль хамгаалагчдын мэргэжлийн болон ажил хэргийн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах; 6/ Байгаль хамгаалагчдыг байгаль орчны чиглэлийн их дээд сургуульд эчнээгээр суралцуулах, давтан сургах, судалгаа авч нэгтгэн танилцуулах; 7/ Удирдах дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт гаргах, иргэдийн өргөдөл гомдлыг барагдуулах; 8/ БОАЖГ-ын үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргах.
4	Улсын /ахлах/ байцаагч	1/Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтын газраас баталсан холбогдох бодлого, төлөвлөлтийг орон нутагт орон хэрэгжүүлэх, тайлагнах; 2/Хариуцсан хяналтын чиглэлээрх аж ахуй нэгж байгууллагын дотоодхяналтыг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн хэрэглээ, үйлчилгээний соёл, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, иргэд, бизнес эрхлэгчдийг

		мэдээлэл, зөвлөмжөөр хангах; 3/Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах; 4/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж хуулийн хугацаанд шийдвэрлэх; 5/аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; 6/Улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх; 7/Шаардлагатай тохиолдолд хариуцсан хяналтын чиглэлээрх сумдын улсын байцаагчийн хяналт шалгалтын баримт бичиг, албан бичгийг хянах, зохих стандартыг шаардлага мөрдүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх, сургаж мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах; 8/Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх; 9/ Улсын байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
5	Дотоод хяналт шалгалт, байгалийн гамшиг, хөрс хамгаалал, цөлжилт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн	Нэг. Цөлжилтийг бууруулах 1/ Газрын элэгдэл, эвдрэлийн зэрэглэл, цөлжилт, хээршилтийн төрөл, ангиллыг тогтоох, тэдгээртэй тэмцэх, нөхөн сэргээх талаар гарсан норматив, техникийн баримт бичгийг мөрдүүлэх; 2/Хөрсний доройтол, бохирдлын байдалд дүн шинжилгээ хийж нөхөн сэргээх ажлыг орон нутгийн холбогдох байгууллагууд болон судалгаа, шинжилгээний байгууллагуудтай хамтран төлөвлөн хэрэгжүүлж хяналт тавих; 3/Хөрс, ургамлын нөхөн төлжих боломжийг бий болгох, хөрсний үржил шим, чадамж, газрын даац, багтаамжийг хамгаалах нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; 4/Хөрсийг хамгаалах талаар гарч буй иргэн, хуулийн этгээдийн санаачилгыг дэмжих, хамтран ажиллах, урамшуулах санал боловсруулах; 5/ Хөрс хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд зарцуулахаар газрын төлбөрийн орлогоос тогтоосон хувь хэмжээний зарцуулалтын байдалд хяналт тавих; Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа 6/ Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах; 7/ Албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааны талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах; Гурав.Дотоод хяналт

		8/ Байгууллагын үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж удирдлагад танилцуулах; 9/ Дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
6	Усны асуудал, төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	Нэг. Усны нөөц баялгийг хамгаалах 1/ Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах; 2/ Аймгийн усны мэдээллийн сан бүрдүүлэх, усны тооллого явуулах ажлыг зохион байгуулах; 3/ Усны нөөцийг ашиглах, усны орчинг нөхөн сэргээх, хамгаалах; 4/ Ус ашиглах зөвшөөрлийн асуудлыг хариуцах; 5/ Усны үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах; Хоёр. ТББ-уудтай ажиллах 6/ Орон нутагт ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын судалгаа гаргаж, хамтран ажиллах; Гурав. Судалгаа шинжилгээний ажил 7/ Байгалийн нөөц баялгийн судалгааг эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хийж, судалгаа шинжилгээний ажлын талаарх үйл ажиллаганы төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.
7	Биологийн төрөл зүйл,мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	Нэг. Биологийн төрөл зүйлийн ашиглалт хамгаалалт 1/ Ан амьтан, байгалийн ургамал хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, бусад шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 2/ Ан амьтан, байгалийн ургамлын нөөц тогтоож, ашиглалтыг зохицуулах, нөхөн сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх; 3/ Ан амьтан, байгалийн ургамлын /бэлчээрийн ургамлын/ нөөцийг эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын менежментийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих; 4/Ан амьтан, байгалийн ургамал ашигласны төлбөрийн хураамж, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих; 5/Ан амьтан, байгалийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх нөхөрлөлийн үйл ажиллагаанд бүртгэлээр хяналт тавих, тэдгээрийг бодлогоор дэмжиж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах. Хоёр. Мэдээллийн сан 7/Байгалийн нөөц баялагийн мэдээллийн сангийн мэдээ баримтыг нэгтгэн бүрдүүлэх, хэрэглэгчдийг байгаль орчны мэдээлэлээр хангах; 8/ Статистик мэдээлэл гаргуулах;
8	Агаарын чанарын асуудал, орчны бохирдол хог хаягдал, химийн хорт бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн	Нэг. Агаарын чанарын асуудал 1/ Агаарын тухай болон Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах; 2/ “Озоны давхрага хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах;

		3/ Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих; Хоёр. Хог хаягдал, химийн хорт бодисын асуудал 4/ Хог хаягдлын тухай хууль тогтоомж, хог хаягдлын талаархи төрийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын нормативыг тогтоож, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх; 5/ Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, санхүүжүүлэх журам болон сумдын Засаг даргатай байгуулах гэрээний биелэлтийг хангуулах; 6/ Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах; 7/ “Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах;
9	Аялал жуулчлал, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Нэг. Аялал жуулчлал 1/ Аймагт үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, зочид буудал, рашаан сувилал, тур операторуудын мэдээллийг жил бүр шинэчлэн гаргаж, аймгийн ИТХ, Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж байх; 2/ Аялал жуулчлалын маршрут, шинээр бий болсон аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, эвент үйл ажиллагааны талаар байгууллага, иргэдийг мэдээллээр хангах, аялал жуулчлалын чиглэлийн сургалт, судалгааны ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; 3/ Орон нутагт аялал жуулчлалын дэд бүтцийг бүрдүүлэх, шинэ бүтээгдэхүүн бий болгох, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын менежментийг хэрэгжүүлэх; 4/ Удирдах дээд байгууллагын шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, зөвлөгөө дэмжлэгээр хангах; 5/ Аялал жуулчлалын статистик мэдээ, мэдээллийг аймгийн, холбогдох цахим хуудсанд байршуулах. Хоёр. Сургалт сурталчилгаа 9/ Байгаль орчны боловсролыг түгээн дэлгэрүүлэх, байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлгөөн, сургалт семинар, сурталчилгаа зохион байгуулж; 10/ Мэдээлэл сурталчилгааны төв, эко гэр ажиллуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах.
10	Ойн ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн	1/ “Ойн тухай үндэсний хөтөлбөр, Монгол орны ховор ургамлыг хамгаалах, зохистой ашиглах үндэсний хөтөлбөр”, “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах; 2/ Ойжуулалт, ой нөхөн сэргээх, үржүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилтэнд технологийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах, төсвөөс хуваарилсан хөрөнгийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах; 3/ Ойн нэгж, сум дундын ойн ангийг бодлогоор хангах.

11	Ойн нэгжийн дарга	Нэг. Ойн баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт 1/ “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах; 2/ Ойн тухай хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах; 3/ Ойжуулалт, ой нөхөн сэргээх, үржүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилтэнд технологийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах, төсвөөс хуваарилсан хөрөнгийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах; 4/Сум дундын ойн ангийг удирдан зохион байгуулж, бодлогоор хангаж ажиллах; 5/Ойн нөөц ашигласны төлбөр хураамж, Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын менежментийн төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих; 6/ Бүх нийтээр мод тарих өдрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах; Хоёр. Сумдыг удирдлага мэдээллээр хангах 6/Сумдын өөрөө удирдах ёсны болон захиргааны байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах; 7/Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг зохион байгуулах, ойн мэргэжлийн байгууллагыг удирдлага, зохицуулалтаар хангах.
12	Ойжуулалт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (нэгжийн мэргэжилтэн)	Нэг. Ойжуулалт 1/ Ойн сангийн мэдээ тайлан гаргах; 2/ Ойн үрийн аж ахуйг хөгжүүлэх, мод үржүүлгийн газар байгуулах, ойн зурвасыг эрхлэн зохион байгуулах; 3/ Төв суурингийн цэцэрлэгжүүлэлт, Бүх нийтээр мод тарих өдрийн хавар намарт зохион байгуулах; 2.Мэдээллийн сан Байгууллагын вэб хуудасны баяжилт хийх; Байгууллагын танилцууллага хийх; Тухайн жилийн хийсэн ажлын тайланг видео, шторкоор хийх.
13	Байгаль хамгаалагч	1. Байгаль орчны тухай үндсэн мэдлэг, байгаль хамгаалах уламжлалт ёс заншил, хууль тогтоомжуудыг сурталчлан дэлгэрүүлж иргэд аж ахуйн нэгж, байгууллагуудын байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд оролцох идэвх санаачлагыг өрнүүлэн, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх; 2. Байгалийн нөөц баялагийг хамгаалах нөхөн сэргээх, зөрчлийг хянан илрүүлэх, таслан зогсоох, хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд гэм буруутай этгээдэд арга хэмжээ авч шийтгэл ноогдуулах; 3. Байгаль орчинд гарч буй өөрчлөлтийг ажиглан, үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авахуулж, мэдээллийн санд оруулах; 4. Хүн амд байгаль хамгаалах мэдлэг хүмүүжил олгох, үндэсний өв уламжлалыг эзэмшүүлэхэд туслах; 5. Байгаль орчны тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах,

		хүрээлэн буй орчин, байгалийн нөөц ашиглах явцад гарч болох зөрчлөөс сэргийлэх ажлыг зохион байгуулах; 6. Хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялагийг хамгаалах арга хэмжээ авах; 7. Хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн нөөц баялагийг ашиглах эрхийн бичиг олгох; 8. Хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялагийг нөхөн сэргээх болон биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 9. Биологи, түүх соёл, палентлоги, геологийн хувьд ач холбогдол бүхий газруудыг онцлон хамгаалах; 10. Хариуцсан нутаг дэвсгэрт байгалийн нөөц баялаг ашиглах үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах; 11. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуульд заагдсан эрх хэмжээний хүрээнд арга хэмжээ авах, захиргааны шийтгэл ноогдуулах; 12. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялагийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих; 13. Байгаль орчны хяналтын ажлын тайлан мэдээг тогтоосон хугацаанд заавар журмын дагуу гаргаж, Засаг дарга, улсын байцаагчид танилцуулан удирдлага тусалцаа авах; 14. Хариуцсан нутаг дэвсгэрт байгаль орчны өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах; 15. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачлагыг өрнүүлэх, зааж зөвлөн туслах,зохион байгуулах,хамтарч ажиллах.
14	Нягтлан бодогч	1. Нягтлан бодох бүртгэлийг зохион байгуулж, үр дүнг тооцох. Санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах ; 2. Төрийн сантай төлбөр тооцоо хийж, мэдээг хүргүүлэх; 3. Нягтлан бодогч, эд хариуцагч нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх; 4. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох Цалин бодож НДШ, ХАОАТ-ын тооцоо хийх; 5. Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан анхан шатны маягтыг зааврын дагуу хөтлүүлэх, хяналт тавих; 6. Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн маягтуудыг аргачлалын дагуу бүрэн хөтлөх; 7. Хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавих; 8. Эд хариуцагчнарын анхан шатны маягт хөтлөлт, тайлан гаргалтанд хяналт тавих;

		9. Сангийн сайдын 2017 оны 361 тоот тоот тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт ,тайлан бэлтгэх, гаргах аргачлалын дагуу салбарын санхүүгийн тайланг НББОУС-д нийцүүлэн гаргах; 10. Салбарын санхүүгийн тайланг улирал, жилээр хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргаж нэгтгүүлэх; 11. Байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллээр хангах; 12. Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан төрийн сангийн төлбөр тооцооны журам, мөнгөн кассын ажиллагааны журамыг мөрдөж, төлбөр тооцоонд хэрэглэгдэх маягт аргачлалын дагуу мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог явуулах; 13. Байгууллагын хөрөнгийн орлого,зарлагын баримт, санхүүгийн тайланд 2 дугаар гарын үсэг зурах; 14. Төрийн сангийн хэлтэст төсвийн орлого, зарлагын мэдээг сар бүр гаргах.
15	Архив бичиг хэрэг	1.Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” /MNS 5140:2011/-ыг мөрдөж ажиллах; 2. Байгууллагад ирсэн өргөдөл, гомдол, ирсэн, явуулсан албан бичиг, байгууллагын даргын тушаалыг бүртгэн авч, шийдвэрлэх хугацаанд хяналт тавих, шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам гаргаж тайлагнах; 3. Байгууллагын бүх төрлийн хэвлэмэл хуудасны захиалга, ашиглалт, зарцуулалтыг бүртгэлжүүлж, зарцуулалтад хяналт тавин ажиллах; 4. Ирсэн бичгийн бүртгэлийн тэмдэг, боловсруулсан тэмдэг болон бусад тамга тэмдэг, баталгааны тэмдгийг журмын дагуу хийлгэж, хэрэглэх, хадгалалт, ашиглалтад хяналт тавих; 5.“Архивын тухай”,“Хөдөлмөрийн тухай”, “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Тамга, тэмдэг хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар” зэрэг хууль тогтоомжууд, бусад холбогдох стандартуудыг байгууллагын хэмжээнд мөрдүүлж ажиллах; 6. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем www.agms.mn вэб програмыг иж бүрэн ашиглаж, байгууллагад ирсэн бүх төрлийн бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг програмаар хүлээн авч танилцах, бүртгэх, удирдлагад шилжүүлэх, шийдвэрлэлтэд хяналт тавих; 7. Байгууллагын явуулж буй бүх бичгийг Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системд бүртгэж, боловсрол, соёлын байгууллагуудад цахим хэлбэрээр илгээж ажиллах; 8. Байгууллагын захирамжлалын баримт бичгийн боловсруулалт, хэвлэмэл хуудсанд буулгах, бүртгэл, дугаар олголтын ажлыг албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн программын орчинд хийж гүйцэтгэх;

		9. Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, нийслэлийн баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар оруулж батлуулан байгууллагын хэмжээнд мөрдүүлэх; 10. Архивын заавар, журмын дагуу албан хаагчдаас архивын хадгаламжийн нэгжийг хүлээн авч, хадгалах, хадгаламжийн нэгж бүрдүүлж буй байдалд хяналт тавих; 11. Хүлээн авсан баримтад техник боловсруулалт хийж, данс бүртгэл, жагсаалт үйлдэх, архивын тоо бүртгэлийг зааврын дагуу хөтлөх, баримтад тооллого хийж, илэрсэн зөрчлийн тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах, мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх; 12. Архивын чиглэлээр өөрийн мэдлэг боловсролыг байнга дээшлүүлж, холбогдох хууль, эрх зүйн актыг албан хаагчдад сурталчлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; 13. Төрийн архивт шилжүүлэх баримтын данс бүртгэл үйлдэж, графикийн дагуу хүлээлгэн өгөх; 14. Цахим архивын санг бүрдүүлж, байнга баяжуулах; 15. Архивын баримтыг мэдээлэл лавлагааны зорилгоор албан хаагчид, холбогдох байгууллага, иргэнд ашиглуулах.
16	Нярав	1. Байгууллагын эд хогшилд зохих журмын дагуу бүртгэл хөтлөн, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, эд хөрөнгө хариуцагчийн карт хөтлөх; 2. Эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж тооллогын комисс даргад танилцуулах; 3. Материалын анхан шатны бүртгэлийг хөтөлж, улирал бүр тайлан гаргах; 4. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа байгууллага, албан хаагч, иргэдийн нууцыг хадгалах; 5. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг дээд зэргээр сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх; 6. Удирдлагын шийдвэр, өгсөн үүрэг даалгавар, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан чиг үүрэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлж, журмаар тогтоосон дэг журмыг мөрдөж, биелэлтийг тайлагнаж захирах, захирагдах ёсыг баримтлан ажиллах; 7. Ажлын цагийг үр бүтээлтэй бүрэн ашиглаж, ажлын цагаар гадуур ажлаар явах болон түр эзгүй байх үед зохих бүртгэлийг хийн, өрөө тасалгааны түлхүүрийг тусгай лац, ломбо тавин хүлээлцэж мэдээлэх, ажилд ирэх, ажлын өдөр дуусч гарахдаа өөрийн биеэр цагаа бүртгүүлж байх; 8. Үүрэгт ажилдаа хариуцлага санаачлагатай ажиллаж, эрхэлсэн ажилдаа шинэ дэвшилтэт арга, санал санаачлагыг хэрэгжүүлж, боловсронгуй болгох арга хэлбэрийг байнга эрэлхийлж ажиллах.

17	Жолооч	1. Машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад машин техникээр үйлчилэх; 2. Замын хөдөлгөөний дүрэмийг баримталж осол авааргүй ажиллах; 3. Хариуцсан машин техник хэрэгслийг бүрэн бүтэн байлгах, эвдрэл саатлыг тухай бүрзасварлаж байх; 4. Багаж, материал, техник хэрэгслийг хамгаалж ажиллах; 5. Удирдлагын зүгээс болон ахлах мэргэжилтний өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах;
18	Ногоон байгууламжийн сахиул	1. Ажлын байрны аюулгүй байдал, эд материалыг бүрэн хариуцаж, засаж янзлах, сэлбэж сэргээх ажлыг хариуцаж ажиллах; 2. Мод үржүүлэгчийн хашаанд хөрс бэлтгэх, хүлэмжинд тарьц, суулгац ургуулах ажилд ойн мэргэжилтний зөвөлгөө тусалцааг авч, арчилгаа усалгааг тогтмол цагт хийж гүйцэтгэх; 3. Мод үржүүлгийн хашаанд байрлах агуулах дотор байгаа эд зүйлийг эмхлэн цэгцлэж, засаж янзлах; 4. Ажлын байранд хариуцсан эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах. 5. Байгууллагаас зохион байгуулсан нийтийг хамарсан болон олон нийтийн ажилд оролцох.
19	Жижүүр	1. Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, хууль бус үйлдэл, хулгай дээрэм гэнэтийн аюулаас хамгаалах, нүдээр харж хүлээлцэх, гадагш гаргахгүй байх; 2. Байгууллагын эд хөрөнгийн эвдрэл гэмтлийг засаж сэлбэх үйл ажиллагааг зохион байгуулах; 3. Ажилтнуудын цагийн бүртгэлийг үнэн зөв хөтөлж, ажлын цагаар гарсан ажилтнуудыг ямар ажлаар гарсныг нэг бүрчлэн асууж, цагийн баланс дээр тэмдэглэгээ хийж, дэг журмыг сахиулах; 4. Албан ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ гал түймэр, ус алдах, гадны халдлагад өртөх зэрэг гэнэтийн аюул гарахаас урьдчилан сэргийлж, сонор сэрэмжийг дээшлүүлэн ажиллах бөгөөд гарсан тохиолдолд яаралтай арга хэмжээг авч хэрэгжүүлэх бэлтгэлтэй байх; 5. Жижүүрийн үүрэгт ажил дуусахаас өмнө байгууллагын гадна, дотор хэсэгт цэвэрлэгээ хийх.
20	Үйлчлэгч	1. Цэвэрлэгээний стандартын дагуу өдөр тутам өрөө тасалгаануудад чийгтэй цэвэрлэгээ хийх; 2. Урсгал болон улирлын чанартай жижиг засварын ажлыг чанартай хариуцлагатай хийж гүйцэтгэх; 3. Цэвэрлэгээний багаж хэрэгсэл болон угаалгын бодис, материалыг заагдсан хугацаанд нярвын тооцооны дагуу авах; 4. Тоног төхөөрөмжийг цэвэрлэх явцдаа эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд холбогдох албан хаагчид эсвэл удирдлагад мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авхуулах; 5. Хайхрамж, болгоомжгүй үйлдлийн улмаас өөрийн болон бусдын биед, байгууллагын өмч хөрөнгөд хохирол учруулахгүй байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх ажлыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэх.



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/205

Зуунмод

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дүгээр зүйлийн 38.1, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.3.Зуунмод сумын 1-р багийн цэлмэг хотхоны баруун тал 20 тоотын 4110062203 нэгж талбарын амины орон сууцны зориулалттай 0.03 га газар эзэмшигч Бямбасүрэнгийн Нямжав (НЮ81020818)-ийн газар эзэмших эрхийн гэрчилгээг Буяндэлгэрийн Энхзаяа (УП89071801)-д шилжүүлэн 8 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Б.Энхзаяа /УП89071801/-д ҮҮРЭГ БОЛГОХ нь:

2.1.Газрыг зориулалтын дагуу эзэмших.

2.2.30 хоногийн дотор газрын кадастрын зураглалыг хийлгэж, мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг egazar.gov.mn цахим системээс авах.

2.3.Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн, цахимаар ирсэн нэхэмжлэлээр газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Зуунмод сумын Засаг даргын 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/505 дугаар захирамжийн холбогдох хэсгийг, 000688564 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал), Зуунмод сумын Засаг дарга (Ч.Сарангэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010528

My.Doc.zahiranj 2023-1 uliral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/206

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албаны хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагаа, Хүний нөөцийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд аймгийн хэмжээнд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар байгуулсугай.

2.Хяналт шалгалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Хяналт шалгалтыг 2023 оны 03 дугаар сарын 31-ээс 04 дүгээр сарын 06-ны хооронд явуулж, дүнг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч нарт үүрэг болгосугай.

4.Ажлын хэсгүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010527

My doc:zahiramj 2023-1 uliral. s/maa

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 28 -ны өдрийн
А/206 дугаар захирамжийн 7 дүгээр хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУВААРЬ

Ажлын хэсэг			Хяналт шалгалтад хамрагдах	
Дугаар	Ахлагч	Гишүүд	Хэлтэс, агентлаг	Сум (ИТХ, ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, СТ)
1	Т.Хуягбаатар (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)	Л.Цэрэнноров (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн) Б.Мөнхбат (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)	1. Мал эмнэлгийн газар;	1. Мөнгөнморьт
			2. Улсын бүртгэлийн хэлтэс;	2. Баяндэлгэр
			3. Эрүүл мэндийн газар (Зоонозын өвчин судлалын албатай);	3. Эрдэнэ
			4. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс.	4. Архуст
			5. Ус, цагуур, орчны шинжилгээний төв;	5. Баянжаргалан
			6. Албан бус насан туршийн боловсролын төв	6. Баян
				7. Зуунмод
				8. Сэргэлэн
				9. Баянцагаан
2	Г.Мөнхгэрэл (Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга)	А.Доржпүрэв (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн) Ц.Баярцэцэг (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)	1. Байгаль орчин, аялал жуулчлалын газар;	1. Баянчандмань
			2. Биеийн тамир, спортын газар;	2. Батсүмбэр
			3. Боловсрол, шинжлэх ухааны газар	3. Борнуур
			4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	4. Жаргалант
			5. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;	5. Сүмбэр
			6. Соёл, урлагийн газар;	6. Баянцогт
			7.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар;	7. Угтаалцайдам

3	С.Магнайбаяр (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, ТАЗСЗ-ийн гишүүн)	Д.Сэдэд (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх хэлтсийн мэргэжилтэн) Д.Бадамсүрэн (Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)	8. Аймгийн Нэгдсэн эмнэлэг	8. Цээл
			9. Нийтийн номын сан	9. Заамар
			1. Аймгийн ЗДТГ	1. Алтанбулаг
			2. Нийгмийн даатгалын хэлтэс	2. Аргалант
			3. Орон нутгийн өмчийн газар (Худалдан авах ажиллагааны албатай);	3. Баянхангай
			4. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба;	4. Лүн
			5. Стандарт, хэмжил зүйн хэлтэс;	5. Өндөрширээт
			6. Статистикийн хэлтэс;	6. Эрдэнэсант
			7. Хүнс, хөдөө аж ахуйн газар;	
			8. Татварын хэлтэс;	7. Дэлгэрхаан
			9. Аймгийн Музей	8. Бүрэн
			10. Монгол туургатан театр	9. Баян-Өнжүүл

ЖИЧ: Хэлтэс, агентлаг, харьяа байгууллага, сумд “Шүүр” ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажил, “Хүний нөөцийн аудит”-ын зөвлөмж (2022 онд хамрагдсан байгууллага)-ийн хэрэгжилт, тайланг урьдчилан бэлтгэсэн байвал зохино.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА,
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТӨВ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.ОТГОНБАТ


ГАРГАСАН:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.МӨНХГЭРЭЛ



Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 28-ны өдрийн
А/206 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ УДИРДАМЖ

Зорилго: Төрийн албаны хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагаа, Хүний нөөцийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг бодит нөхцөл байдал, судалгаанд тулгуурлан хянаж шалгах.

Зорилт:

1. Төрийн албаны чадамжийг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй ажил, төрийн албанд иргэнийг томилж, чөлөөлөх ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх. (Судалгааны маягт 1, маягт 2)

2. Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцооны цахим системийн баяжилт, ашиглалтад хяналт тавих. (Цаасан болон Цахим систем)

Хамрагдах байгууллага, хязгаарлалт: 25 хэлтэс, агентлаг, харьяа байгууллага, 27 сумын Засаг даргын Тамгын газар, ИТХ-ын Ажлын алба, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв

Хугацаа: 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 06-ны өдөр хүртэл

Арга зүй: Хууль тогтоомжийн нийцэл, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 5 дугаар хуралдаанаас зөвшөөрсөн “Хүний нөөцийн аудит хийх гарын авлага”-д дурьдсан арга зүйд тулгуурлан баримт бичгийн шинжилгээг шалгуур үзүүлэлттэй харьцуулж, тодруулга мэдээллийг ярилцлага, ажиглалт (зураг авалт)-д тулгуурлан хийж, үр дүнг нэгтгэнэ.

Шалгуур үзүүлэлт: Дараах хууль тогтоомж, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

1. Төрийн албаны тухай хууль (2019.01.01)

-Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам (ТАЗ-ийн 2022 оны 600 дугаар тогтоол)

-Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам (ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоол, өмнөх журмууд)

2. Хөдөлмөрийн тухай хууль

3. Авлигын эсрэг хууль

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

5. Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам (МУЗГ-ын 2019 оны 74 дүгээр тогтоол)

6. Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам (МУЗГ-ын ХЭГ-ын дарга, ТАЗ-ийн дарга нарын 2019 оны 34/39 дүгээр хамтарсан тушаал)

7. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” (МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоол)

Тайлан: Хяналт шалгалтын тайланг байгууллага, сум тус бүрээр; нэгдсэн дүгнэлтийг илтгэх хуудсаар 2023 оны 04 дүгээр сарын 07-ны дотор танилцуулна.

Хяналт, шалгалт хийх үзүүлэлт:

№	Зорилт	Үзүүлэлт	Тайлбар
1	Төрийн албаны чадамжийг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй ажил, төрийн албанд иргэнийг томилж, чөлөөлөх ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх. (Судалгааны маягт 1, маягт)	Батлагдсан бүтэц, орон тоо, түүний дагуу ажиллаж байгаа эсэх	Байгууллага
		Албан тушаалын тодорхойлолтын баталгаажуулалт	Албан тушаал бүрээр
		Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжилт.	Албан хаагч бүрээр
		Томилсон, чөлөөлсөн шийдвэр(2022-2023)	Албан хаагч бүрээр
		2023 оны 01 дүгээр сарын 01-ээс хойших цалин олгосон цэс(Баталгаажуулж авах)	Зөрчилтэй томилгоотой албан хаагч тус бүрээр
2	Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцооны цахим системийн баяжилт, ашиглалтад хяналт тавих. (Цаасан болон Цахим систем)	Цахим системийн хөтлөлт, баяжилт	Албан хаагч бүрээр
		Албан тушаалын тодорхойлолт цахимжуулсан байдал	Албан тушаал бүрээр

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТӨВ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 8/208

Зуунмод

Хяналт шалгалтын ажлын хэсэг
байгуулж, зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2.1, 2.4 Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 13 дугаар хуралдааны 2 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Уул уурхай бүхий сумдад ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Г.Сурмаа (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Б.Насанжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Л.Нямдаваа (Онцгой байдлын газрын орлогч дарга)

Ү.Бат-Эрдэнэ (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Г.Билгүүн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч)

С.Эрдэнэцогт (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн)

М.Цогжавхаа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ж.Даш-Яйчил (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

2. Хяналт шалгалтын ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Хяналт шалгалт хийхэд шаардагдах 2,670,000 (хоёр сая зургаан зуун далан мянга) төгрөгийн зардлыг аймгийн 2023 оны Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хяналт шалгалтын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

4123010531

My doc:zahiramj 2023-1 uliral. s/maa

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн 2023 оны 05 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Ажлын хэсгийн дарга (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 28 ны өдрийн
А/208 дугаар захирамжийн хавсралт



АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЖ БУЙ
АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА НӨХӨРЛӨЛҮҮДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН
ХЭСГИЙН УДИРДАМЖ

2023.03.27

Зуунмод

Нэг: Зорилго.

Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Газрын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Алтанбулаг, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл, Борнуур, Жаргалант, Эрдэнэ, Баянчандмань, Сүмбэр, Лүн, Заамар сумдад ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж байгууллага нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж орон нутгийн удирдлагыг мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр хангаж ажиллахад удирдамжийн зорилго оршино.

Хоёр: Зорилт.

1. Ашигт малтмал олборлож буй аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөх.
2. Бичил уурхай эрхлэгчид болон хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж үнэлэлт дүгнэлт өгөх.

Гурав: Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгаа байдал
2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлж байна.
3. Ашиглалтын талбайг тогтоосон хэмжээгээр зориулалтын дагуу батлагдсан төлөвлөгөөний дагуу ашиглаж буй байдлыг шалгах.
4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил түүн дотроо биологийн нөхөн сэргээлтийн ажлыг явцыг шалгах
5. Аймаг, сумтай байгуулсан 2021 оны байгаль орчныг хамгаалах болон ус ашиглах, газар ашиглах, уул уурхайн нөхөн сэргээлтийн гэрээнүүдтэй танилцах, гэрээ байгуулах
6. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн мөрдөлт, харуул хамгаалалтын байдлыг шалгах.
7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлсэн ажил түүний биелэлт
8. Бичил уурхай эрхлэгчид болон хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн судалгаа нарийвчлан гаргуулах
9. Бичил уурхайн нөхөрлөл үүдтэй өмнөх онуудад байгуулсан гэрээний хэрэгжилт, үйл ажиллагаа явуулсан газруудад нөхөн сэргээлт хийсэн байдал, хэрэгжилтийг шалгасан эсэх талаар дүгнэлт гаргуулах.

10. Нөхөрлөлүүдийн холбогдох байгууллагаас авсан зөвшөөрөл, баримт бичгийг шалгах

11. Үйл ажиллагаа явуулж буй тоног төхөөрөмж, талбайн шав тэмдэг, зөвшөөрөгдсөн талбайд үйл ажиллагаа явуулсан эсэх, нөхөн сэргээлтийн гэрээ түүний хэрэгжилтийг шалгах.

12. Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газруудын хамгаалалтыг шалгаж дүгнэлт гаргах, зурагжуулах

13. Хууль бус гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох, нэмж талбай хөндүүлэхгүй байх тал дээр онцгой анхаарч ажиллах.

Дөрөв: Хамрах хүрээ.

Алтанбулаг, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл, Борнуур, Жаргалант, Эрдэнэ, Баянчандмань, Сүмбэр, Лүн, Заамар сумдад ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагдаж буй, аж ахуйн нэгж байгууллага, нөхөрлөл, иргэд.

Тав: Хугацаа.

2023 оны 04 дүгээр сарын 05-аас 05 дугаар сарын 31-ний хугацаанд.

Зургаа: Хүрэх үр дүн.

Хууль, журмын хэрэгжилтэд үнэлэлт өгч, холбогдох арга хэмжээг газар дээр нь шийдвэрлүүлж, цаашид авч хэрэгжүүлэх бодлого чиглэлийг тодорхойлж хуулийн хэрэгжилт хангагдана.

Долоо: Унаа, шаардагдах зардал, төсөв.

Ажлын хэсэгт орсон байгууллагууд өөрсдийн унааг гаргаж аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2023 оны хяналт шалгалтын зардлаас шатахууны зардлыг шийдвэрлэнэ.

Найм: Хяналт шалгалт явуулах ажлын хэсэг.

- Аймгийн Засаг даргын Тамгын газар
- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
- Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
- Сумдын Засаг даргын Тамгын газар

Ес: Маршрут.

1-р хэсэг. Эрдэнэ, Баян, Сэргэлэн, Баянцагаан, Баян-Өнжүүл Зуунмод-Эрдэнэ-90км, Эрдэнэ суман дотор 80км, Эрдэнэ-Баян-100км, Баян суман дотор 120км, Баян-Баянцагаан 90км, Баянцагаан суман дотор 60км, Баянцагаан-Баян-Өнжүүл-110км, Баян-Өнжүүл суман дотор 80км, Баян-Өнжүүл-Сэргэлэн 130км, Сэргэлэн суман дотор 250км, Сэргэлэн-Зуунмод 20км = Нийт 1130км

2-р хэсэг. Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Жаргалан, Сүмбэр Зуунмод-Алтанбулаг-50км, Алтанбулаг суман дотор-100км, Алтанбулаг-Баянчандмань 100км, Баянчандмань суман дотор 60км, Баянчандмань-Борнуур-40км, Борнуур суман дотор 100км, Борнуур-Жаргалант-40км, Жаргалант суман дотор 50км, Жаргалант-Сүмбэр 70км, Сүмбэр суман дотор-60км, Сүмбэр-Зуунмод 190км = Нийт 860км

3-р хэсэг. Лүн, Заамар

Зуунмод-Лүн, 150км, Лүн суман дотор 50км, Лүн-Заамар-100км, Заамар суман дотор 500км, Заамар- Зуунмод 230км = Нийт 1030км 1130+860+1030=3020км

№	Унаа гаргах байгууллага	Машины марк	Шатахууны хэмжээ	Нэгж үнэ	Мөнгөн дүн
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	Prado-150	100км=20л 604л	2390	1.443.560,0
2	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Уаз пургон	100км=17л 513,4л	2390	1.227.026,0
	Нийт дүн				2.670.586,0

Арав: Дүн мэдээ гаргах тайлагнах.

Ажлын хэсэг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ цаашид авч хэрэгжүүлэх ажлын санал дүгнэлтээ боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулан холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлж ажиллана.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ЭРДЭНЭЦОГТ





ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/210

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2023 онд хэрэгжүүлэх "Баянцогт сумын Гунын хөв цөөрмийн даланг сэргээн засварлах ажлын зураг төслийг хийлгэх ажил"-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Т.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Гишүүдэд:

А.Алтансүвд (Аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци
ОНӨААТҮГ-ын инженер)
Ц.Нямгарав (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн)
Д.Сэдэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичиг:

Э.Номин-Эрдэнэ (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан
авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2."Баянцогт сумын Гунын хөв цөөрмийн даланг сэргээн засварлах ажлын зураг төслийг хийлгэх ажил"-ын гүйцэтгэгч сонгох ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Т.Хуягбаатар)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

4123010544
My.Doc.zahiramj 2023-1 uliral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/211

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2023 онд хэрэгжүүлэх "Сумын төвийн ундны усны худагт ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажил (Архуст, Баян, Баянжаргалан, Баянцагаан сумд)"-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Т.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Гишүүдэд:

А.Алтансүвд (Аймгийн Барилга захиалагч, орон сууцны корпораци
ОНӨААТҮГ-ын инженер)
Ц.Нямгарав (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын мэргэжилтэн)
Д.Сэдэд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичиг:

Э.Номин-Эрдэнэ (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын худалдан
авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2. "Сумын төвийн ундны усны худагт ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах ажил (Архуст, Баян, Баянжаргалан, Баянцагаан сумд)"-ын гүйцэтгэгч сонгох ажлын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Т.Хуягбаатар)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010540

My.Doc.zahiramj 2023-1 ulral



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/213

Зуунмод

Дуудлагын худалдааны ажлын
хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VI хуралдааны 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн өмчийн харилцааг зохицуулах журмын 5.3.8.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн XIV хуралдааны 08, 09 тоот тогтоолоор дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн цагдаагийн газрын автомашинаас бусад тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Батжаргал

(Орон нутгийн өмчийн газрын дарга)

Өмчийн төлөөлөгч:

Б.Баярсайхан

(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч:

Г.Уранцэцэг

(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Хөтлөгч:

Б.Мөнхбаяр

(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Хөндлөнгийн хянагч:

Д.Жаргалмаа

(Дэлгэрхаан сумын Засаг дарга бөгөөд аймгийн ИТХ-ын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны гишүүн),
(зөвшилцсөнөөр)

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж явуулахыг ажлын хэсгийн ахлагч Орон нутгийн өмчийн газрын дарга (Д.Батжаргал)-д даалгасугай.

3. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавихыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010548

My doc:zahiramj 2023-1 uliral. s/maa



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/214

Зуунмод

Дуудлагын худалдааны ажлын
хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VI хуралдааны 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн өмчийн харилцааг зохицуулах журмын 5.3.8.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн XIV хуралдааны 08, 09 тоот тогтоолоор дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн Цагдаагийн газрын тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Доржбалжид (Аймгийн Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа)

Өмчийн төлөөлөгч:

Д.Зоригт (Аймгийн Цагдаагийн газрын цагдаа жолооч, аж ахуйн ажилтны албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, цагдаагийн ахлах ахлагч)

Тэмдэглэл хөтлөгч:

Д.Сэрчиндоо (Аймгийн Цагдаагийн газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч, цагдаагийн дэд ахлагч)

Хөтлөгч:

Б.Мөнхбаяр (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Хөндлөнгийн хянагч:

Д.Жаргалмаа (Дэлгэрхаан сумын Засаг дарга бөгөөд аймгийн ИТХ-ын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны гишүүн),
(зөвшилцсөнөөр)

2. Нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж явуулахыг Ажлын хэсгийн ахлагч Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Н.Доржбалжид)-т даалгасугай.

3. Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавихыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123010551

My doc:zahiramj 2023-1 uliral. s/maa



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/217

Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Захирагч нарын холбооноос жил бүр хэрэгжүүлдэг төрийн албан хаагчдын солилцооны "K2H 2023" тэтгэлэгт хөтөлбөрт 2023 оны 04 дүгээр сарын 12-наас 06 сарын хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч Э.Бүжинлхам хамрагдах тул шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Зардалд шаардагдах 3,819,680 (гурван сая найман зуун арван есөн мянга зургаан зуун ная) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 30-ны өдрийн
А/217 дүгээр захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН НЭГТГЭЛ

№	Зардлын нэр	Нэгжийн үнэ	Нийт
1	Олон Улсын нислэгийн үнэ	3,608,300	3,608,300
2	Визний хураамж	211,380	211,380
Дүн			3,819,680

___оОо___



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/220

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээр хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Сурмаа (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Д.Мөнхцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Д.Саран-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Д.Батцэцэг (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Нарийн бичгийн дарга:

Г.Чанцалдулам (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

2.Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт хэлэлцээрийн төслийг ажлын хэсгийн түвшинд боловсруулан хэлэлцүүлж, ойлголтуудаа нэгтгэн, журмын дагуу 2023-2025 оны хэлэлцээрийг байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хороонд хүргүүлэхийг аймгийн Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт салбар хороо (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/221

Зуунмод

Жендерийн эрх тэгш байдлыг
хангах салбар хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий салбар хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар хорооны дарга:

(Аймгийн Засаг дарга)

Салбар хорооны дэд дарга:

(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

(Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

(Цэргийн штабын дарга)

(Статистикийн хэлтсийн дарга)

(Төв аймаг дахь Цагдаагийн газрын дарга)

(Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)

(Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

(Аймгийн Соёл, урлагийн газрын дарга)

(Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

(Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

4123010555
My Doc. xaltamj 2023-1-10

(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

(Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга) (зөвшилцсөнөөр)

(Аймгийн Эрэгтэйчүүдийн холбооны тэргүүн) (зөвшилцсөнөөр)

(Аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн) (зөвшилцсөнөөр)

(Мерит төслийн зохицуулагч) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

(Нийгмийн бодлогын хэлтсийн Жендер, хүн амын хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллахыг салбар хорооны бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/07 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР